



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 03/02

Хөхбүрд

Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх
"Мөрийн хөтөлбөр" батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дүгээр заалтыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Мөрийн хөтөлбөр"-ийг 10 зүйл 64 заалтаар хэрэгжүүлэхээр хавсралтаар баталсугай.

2. Мөрийн хөтөлбөр, "Хөгжлийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинд тулгуурлан, батлагдсан маягтын дагуу гаргаж, тайлагнаж ажиллахыг Засаг дарга (Т.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо (Д.Нямсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Б.ЭРДЭНЭБААТАР



642401053



وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه - جمهوری اسلامی ایران
وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه

وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه

فمنس ۷۷/۷۰

۷۷/۷۰ و ۷۷/۷۰

جمهوری اسلامی ایران - وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه
وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه

جمهوری اسلامی ایران - وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه
فمنس ۷۷/۷۰ و ۷۷/۷۰
وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه

جمهوری اسلامی ایران - وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه
وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه

جمهوری اسلامی ایران - وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه

وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه
وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه

وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه

وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه



وزارت معارف و اوقاف و صنایع مستظرفه

642401047

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 28 ны
өдрийн 04 ээлжит 3 дугаар хуралдааны
2 тогтоолын хавсралт

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.

1.1. Сурч, хөгжих ая тухтай орчныг бүрдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл иргэнийг төлөвшүүлнэ.

1.2. Залуу гэр бүлийг орон нутагт амьдрах боломжоор хангаж, орон сууцны ипотекийн 3 хувийн зээлд хамруулах хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3. Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж, тэдний мэргэжлийн болон багшлах ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн "Сайн багш" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.4. Үндэсний бичиг болон хос бичигтэн болох Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэжүүлэх ажлыг эрчимжүүлэх.

1.5. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийсэн иргэн, ААН, байгууллагыг бодлогоор дэмжинэ.

1.6. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны стандартыг мөрдөж шим тэжээлээр баялаг хүнс, Сүү хөтөлбөр хэрэгжүүлж "Өдөр бүр нэг аяга" сүүгээр хангах ажлыг эхлүүлнэ.

1.7. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг биеийн тамирын гаднах талбай, гадна орчныг сайжруулна.

1.8. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүртээмж, орчин, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүний эрхэд ээлтэй дотуур байр бий болгохыг дэмжинэ.

1.9. ХАА-н салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх чиглэлээр ХААИС-ийн салбар, ХАА-н МСҮТ-үүдтэй хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлнэ.

1.20. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд барина.

1.21. Суралцагч сум ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах.

1.22. Төсөвт байгууллагад хүний нөөцийн судалгаа гаргаж, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх.

1.23. Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суманд хэрэгцээтэй байгаа мэргэжлээр сурч байгаа оюутнуудын судалгааг гаргаж орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах талаар гэрээ хийх.

ХОЁР.ЭРҮҮЛ МЭНД, СПОРТ

2.1.Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, илэрсэн өвчлөлд орон нутагт нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

2.2. Эрүүл хүнс, эрүүл хооллолтыг бодлогоор дэмжиж, иргэдээ эрүүл хүнсээр хангах асуудлыг үе шаттай төлөвлөж хэрэгжүүлнэ.

2.3.Шүд дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.4.Эрүүл мэндийн төвийг шүдний кабинеттай болгох.

2.5.Эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэхэд салбар дундын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулна.

2.6.Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.7.Идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэх дасгал, эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн зориулалтын зам, талбайг байгуулна.

2.8.Орон нутгийн нөөцөд түшиглэсэн олон төрөлт спортыг хөгжүүлнэ.

ГУРАВ.УРЛАГ, СОЁЛ

3.1.Урлаг, соёлын салбарт нэн шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг жил бүр шийдвэрлэхийн зэрэгцээ биет болон биет бус үнэт өвийг хамгаалах, сурталчлах, залуу үедээ уламжлуулан өвлүүлэхийг бодлогоор дэмжинэ.

3.2.Өв тээгчдийг илрүүлж, дэмжиж, урамшуулах, хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.3.Үндэсний өв уламжлал, нүүдлийн ахуй соёлыг шингээсэн уран бүтээл, дижитал контент бүтээгчдийг дэмжинэ.

3.4.Номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, сан хөмрөгийг баяжуулан, үндэсний цахим мэдээллийн санд нэгдэж, иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлнэ.

3.5 Угийн бичиг хөтлөхийн үр дүн иргэдэд сурталчилан таниулах ажлыг эрчимжүүлэх,угийн бичиг хөтлөж хэвшүүлэх .

ДӨРӨВ.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

4.1.Үр ашигтай жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, өрх бүрээс 1 хүнийг тогтвортой ажлын байртай байлгах бодлого хэрэгжүүлнэ.

4.2.Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

4.3."Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг үргэлжлүүлж, "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.4.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.5.Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар сумд дутагдалтай мэргэжилтнүүдийг бүрдүүлэх "Ахмад мэргэжилтний алба" ажиллуулах санаачилга, хөдөлгөөн өрнүүлнэ.

4.6.Өрхийн үйлдвэрлэлийг бүх талаар дэмжиж, бага оврын дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ.

4.7.Орон нутагт Шинэ ажлын байр бий болгосон ААН-үүдийг орон нутгаас урамшуулдаг тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлнэ.

ТАВ. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

5.1.Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ, халамжийн үйлчилгээнд хамрагддаг өрх бүрээс нэг хүнийг мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай болгож, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжинэ.

5.2.Эмч, багш нар болон төрийн албан хаагчдыг орон сууцжуулах бодлогын хүрээнд төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.

5.3.Үүрэн холбооны сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

ЗУРГАА. ӨРХИЙН ӨСӨЛТИЙГ ТЭТГЭСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙ

6.1."Зуданд зутардаггүй хариуцлагатай малчин" хөтөлбөр хэрэгжүүлж малчдыг хот айл, аравт, хорьтын системээр хөдөлмөрөө хорших боломжийг бүрдүүлнэ.

6.2.Малчдын залгамж халааг бэлтгэх зорилгын хүрээнд "Залуу малчин өрхийг дэмжин урамшуулах сумын хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлнэ.

6.3.Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулна.

6.4.Тэжээлийн ургамал тариалах боломжтой бүсүүдэд инженерийн хийцтэй услалтын системүүдийг бий болгож, тариалалтыг нэмэгдүүлэн, МАА-н салбарын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

ДОЛОО.ТОГТВОРТОЙ БАЙГАЛЬ ОРЧИН

7.1.Гадаргын усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулж, түүгээрээ усны хэрэгцээг хүртээмжтэй хангах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

7.2.Хариуцлагатай уул уурхайн зарчмын дагуу нөхөн сэргээлт, хаалтын

асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүрэн хариуцан гүйцэтгэдэг болох асуудлыг шийдвэрлэж ажиллана.

7.3.Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод үржүүлэх, арчлах ургуулах үйлчилгээ бүхий хувийн хэвшил иргэн ААН-үүдийг дэмжинэ.

7.4.Байгалийн баялгаас орж буй орлого, төсөв. тендерийг иргэдээр хэлэлцүүлдэг тогтолцоог шинэ шатанд гаргана.

7.5.Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

7.6.Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч орхигдсон газруудыг нөхөн сэргээнэ.

7.7.Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулж буй гэрээ, газар өмчлүүлэх, эзэмшүүлэх үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангана.

НАЙМ. ХОТ СУУРИНЫ НОГООН ХӨГЖИЛ

8.1.Сумын төвийн гэр хорооллын дахин төлөвлөлтийг эрчимжүүлж, “Шинэ гудамж”, “Ногоон хороолол” төсөл хэрэгжүүлж, өрх бүр хашаандаа мод, хүнсний ногоо тариалж, жишиг гудамжнуудыг бий болгон, төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

8.2.Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээрээ дахин төлөвлөлт хийж, амины орон сууц барих ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

8.3.Гэр бүлийн хэрэгцээний газраа өмчилж авч чадаагүй сумын төвийн өрхүүдэд газрыг нь өмчлүүлэх арга хэмжээг бодлогоор хэрэгжүүлнэ.

8.4.Сум, багийн төвүүдийг шинэчлэх төслийг үргэлжлүүлж, Засгийн газраас хэрэгжүүлэх орон нутгийн автозамын сүлжээнд сумдыг холбох ажлыг эхлүүлнэ.

8.5.Сумд хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, хогийн цэгийг ландфилын аргаар дарж, хог хаягдлыг дахин боловсруулахыг бодлогоор дэмжинэ.

8.6.Нийтийн эзэмшлийн талбайд стандарт шаардлага хангасан боловсон нойлтой болох

ЕС.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

9.1.Бие даасан сум болохыг зорино.

9.2.Орон нутгийн орлогын хэмжээг 30 хувиар нэмэгдүүлнэ.

9.3. Татварын орлогын бааз суурийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

9.4.Хөгжлийн зорилт, төсвийн уялдааг хангасан үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлнэ.

9.5.Засаг захиргааны бүх шатанд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх

чадвартай, авилгаас ангид байж, иргэндээ чанартай үйлчилгээ үзүүлдэг, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай, ардчилсан цахим засаглалыг төлөвшүүлнэ.

9.6.Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж баталсан тогтоолыг хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

9.7.Төрийн албан тушаалтантай холбоотой авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлийн талаар гаргасан иргэдийн мэдээллийг хүлээн авах цахим орчныг бүрдүүлж, түүний нууцыг хадгалж, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж, ил тод хариуцлага тооцох зарчмыг нэвтрүүлнэ.

9.8.Төсвийн ил тод байдлыг хангах шаардлагын дагуу Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулж, ил тод хяналттай төсвийг бий болгоно.

9.9.Төрийн албан хаагчдын цалин хөлсийг ажлын байранд өнгөрүүлсэн хугацаагаар бус ажлын үр дүнгээр тооцдог аргачлалыг нэвтрүүлнэ.

9.10.Өөрийн сумын салбар бүрд шаардагдах боловсон хүчний нөөцийн эрэлт шаардлагад үндэслэн Гадаад дотоодын их, дээд сургуульд гэрээгээр суралцах оюутны тоог үе шаттай нэмэгдүүлнэ.

9.11.Сумын төсвийн гүйцэтгэлд жил бүр нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэд, олон нийтийн төсөвт тавих хяналтыг сайжруулна.

АРАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН, АЯ ТУХТАЙ БАЯН-ОВОО

10.1.Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, аймаг сумын төвийг телекамерийн хяналтад бүрэн авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

10.2. Архины хор уршгийг тайлбарлан таниулж, гэгээрүүлэх замаар “Архигүй Баян-Овоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

10.3.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж “Малын хулгайгүй сум” болохыг зорино.

___оОо___